

UCS.....B2023

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН



Авто засварын үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

1. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
2. НОРМАТИВ ЭШЛЭЛ	3
3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
4. АВТО ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА.....	4
5. АВТО ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	4
6. АВТО ЗАСВАРЫН ГАЗРЫН ГАДНА ЗОГСООЛЫН ТАЛБАЙД ТАВИГДАХ ШААРДЛАГА 4	
7. ГЭРЭЛТҮҮЛЭГ, ХЯНАЛТЫН КАМЕРЫН СИСТЕМ	8
8. УТААТ ТАМХИ ТАТАХ ЦЭГ	9
9. ГАДНА ХАЯГ, БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН БИЧВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА	10
10. АЮУЛТАЙ БОЛОН ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ТҮР ХАДГАЛАХ ЦЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	11
11. ШАЛГАХ ХУУДАС	13
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	14

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН
АВТО ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧНЫ ЕРӨНХИЙ
ШААРДЛАГА

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Авто засварын газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын ажил үйлчилгээ явуулж буй барилга байгууламжийн гадна орчинд тавигдах шаардлагыг тогтоож дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах эш татсан барилгын норм ба дүрэм, стандартыг хэрэглэнэ. Эш татсан дараах баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ.

- БНБД 31-03-03 Олон нийт, иргэний барилгын норм ба дүрэм;
- БНБД 32-01-06 Хот суурины гудамж, зам төлөвлөлтийн норм ба дүрэм;
- БНБД 30.01.04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 3.01.06-09 Барилгын орчны тохижилтын ажил;
- MNS 5025:2020 Авто үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага;
- MNS 0012-3-004:1983 Хөдөлмөр хамгаалал. Автомашины техникийн үйлчилгээ, засвар. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага;
- MNS 5342 Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага;
- MNS 5021 Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага;
- MNS 5011 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдлын үзлэг хийх заавар, ерөнхий шаардлага;
- MNS 5347 Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал Ерөнхий шаардлага;
- MNS 4596 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
- MNS 4597 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4759 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 5537 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж, үндсэн шаардлага;
- UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага
- UCS 1201B:2022 Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага
- UCS 1703A:2022 Аюултай хог хаягдлын менежмент.

3. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Авто үйлчилгээ – гэж авто тээврийн хэрэгслийн техникийн байдлыг оношлох, техникийн үйлчилгээ, засвар хийх, хадгалах, угаалга, цэвэрлэгээ тосолгооны болон ашиглалтын бусад материал худалдах, цэнэглэх, сэлбэг хэрэгсэл худалдаалах зэрэг авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйл ажиллагаа;

Авто засварын үйлчилгээ – гэж авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйл ажиллагааг хэрэглэгчдэд үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

Авто зогсоол – гэж зөвхөн автомашины зогсоолын буюу автомашиныг байрлуулах зориулалтаар байгуулсан барилга байгууламж (барилга байгууламжийн хэсэг), түр буюу удаан хугацаагаар байрлуулах зориулалтын талбай;

Зогсоол дахь явган хүний зам – гэж төвлөрсөн ил болон дотор зогсоолд тусгайлан тэмдэглэсэн явган хүн зорчих зориулалттай зам.

4. АВТО ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Авто засварын үйлчилгээний газар нь иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу харьяа орон нутгийн захиргааны байгууллагад бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авч үйл ажиллагаа эрхэлнэ.
- 4.2. Эрхэлж буй ажил, үйлчилгээ нь хүрээлэн буй орчин, оршин суугчдад сөрөг нөлөө үзүүлэхгүй, галын болон бусад аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, техникийн аюулгүй ажиллагаа, үйлчилгээний соёл, ариун цэвэр, тав тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэн журам тогтоож мөрдүүлсэн байна.
- 4.3. Авто засварын үйлчилгээ газар нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламж, гадна болон дотор зогсоолын талбай, технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байна.
- 4.4. Авто засварын үйлчилгээг үнийн тариф илэрхийлсэн мэдээллийн самбартай байна.
- 4.5. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийн ханган ажиллана.
- 4.6. Авто засварын газрын эзэмшил талбайд 20 хувиас доошгүй зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх /ногоон байгууламж төлөвлөх боломжгүй бол нийтийн эзэмшлийн талбайд агаар орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх/

5. АВТО ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 5.1. “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01-04, “Олон нийт, иргэний барилга” БНБД 31-03-03, “Хот суурины гудамж, зам төлөвлөлт” БНБД 32-01-06-д заасан норматив шаардлагыг хангасаж гадна гэрэлтүүлэг, камержуулалт, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна.
- 5.2. Галын аюулгүйн шаардлагыг бүрэн хангаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбогдсон эсвэл тусгай байгууламжтай байна.
- 5.3. Барилгын тухай хуулийн дагуу үйлчилгээний зориулалтай барилга байгууламж нь холбогдох заалтын дагуу ашиглалтын шаардлага хангасан байна.


6. АВТО ЗАСВАРЫН ГАЗРЫН ГАДНА ЗОГСООЛЫН ТАЛБАЙД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 6.1. Авто засварын газрын гадна зогсоолын талбай нь UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоол төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага хотын стандарт, Хот суурины гудамж зам талбайн төлөвлөлт БНБД 32-01-06 норм дүрэм, стандарт шаардлагын дагуу автомашин байршуулахад зориулсан хатуу хучилт бүхий тэгш талбайтай байна.




Зураг 1. Гадна авто зогсоолын ерөнхий харагдах байдал (Жишээ зураг)

- 6.2. Авто засварын үйлчилгээ явуулах барилга байгууламж “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, “Олон нийт, иргэний барилга” БНБД 31-03-03, “Хот суурины гудамж зам талбайн төлөвлөлт” БНБД 32-01-06, “UCS 1201В:2022 Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага” стандарт, норм дүрэмд заасан шаардлагын дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан автомашины болон явган хүний зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, зогсоолтой байна.
- 6.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зогсоол талбайг тусгайлан тэмдэглэж таних тэмдгээр заасан байх ба үйлчилгээний барилгын гол орц, хаалганаас хамгийн ойр зайд төлөвлөнө.




Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоолын төлөвлөлт (Жишээ зураг)




Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тээврийн хэрэгсэл байршуулах тэмдэглэл
/Өнгө: RGB 207 81 87/ (Жишээ зураг)

- 6.4. Авто тээврийн хэрэгсэл байрлуулах зогсоолын байрлалыг цагаан зураасаар, аюулгүйн тэмдэглэгээг шар зураасаар стандартын дагуу тэмдэглэж, зориулалтын зогсоолоос бусад газарт тээврийн хэрэгсэл байрлуулахыг хориглоно.
- 6.5. Ил зогсоолд замын хөдөлгөөний зохион байгуулалтыг Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн, тэмдэг, тэмдэглэл байрлуулсан байна.
- 6.6. Авто засварын газрын гадна төвлөрсөн ил зогсоолд тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах байдлаар төлөвлөнөв Үүнд:
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах хурд сааруулагчаар тоноглоно;
 - Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих боломжийг бүрдүүлэх үүднээс авто зогсоолын хүрээний дагуу 1,5 м-ээс багагүй өргөнтэй явган хүний замыг төлөвлөх;




Зураг 4. Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан төлөвлөлт (Жишээ зураг)




Зураг 5. Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан төлөвлөлт (Жишээ зураг)

- 6.7. Авто зогсоол нь ус зайлуулах байгууламжтай байх ба хучилтын гадаргуугийн усыг далд байгууламжаар шийдэж Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зурагт төсөл, тооцооны норм /БД 40-302-13/-г баримтлан төлөвлөнө.
- 6.8. Гадна талбайд унадаг дугуйн зогсоолыг төлөвлөх бөгөөд “UCS 0903B:2022 Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартын 14 дүгээр бүлгийн шаардлагууд хангасан байхаар төлөвлөнө.



Зураг 6. Унадаг дугуйн зогсоолын төлөвлөлт (Жишээ зураг)

- 6.9. Авто засварын газрын гаднах ил зогсоолд 10 багагүй хувьд нь цахилгаан тээврийн хэрэгслийн зогсоолыг төлөвлөнө.
- 6.10. Цахилгаан тээврийн хэрэгслийн зогсоолын байршлыг жолоочид мэдээлэх тэмдэг, тэмдэглэлийг байршуулж ногоон өнгөөр ялгаж өгөх, цэнэглэх станцыг ашиглах, төлбөр төлөх зааврыг байршуулна.



Зураг 7. Цахилгаан тээврийн хэрэгслийн зогсоол (Жишээ зураг)

7. ГЭРЭЛТҮҮЛЭГ, ХЯНАЛТЫН КАМЕРЫН СИСТЕМ

7.1. Гадна гэрэлтүүлэг нь авто засварын газрын гадна талбайг бүхэлд нь гэрэлтүүлэх шийдэлтэй бөгөөд “UCS 1901B:2022 Гэрэлтүүлэх төхөөрөмжийг төлөвлөх, байрлуулах, суурилуулах удирдамж”, “UCS 1901B:2022 Гэрэлтүүлэгт тавигдах шаардлага” хотын стандартуудын шаардлагыг хангасан байна.



Зураг 8. Авто засварын газрын гадна гэрэлтүүлэг (Жишээ зураг)

7.2. Гадна, дотор талыг хянах камер суурилуулж, галын аюулгүй дохиоллоор тоногдсон байна.


7.3. Хяналтын камер нь “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага” MNS 6423:2019 стандартын шаардлагыг хангасан байна.



Зураг 9. Хяналтын камер (Жишээ зураг)

8. УТААТ ТАМХИ ТАТАХ ЦЭГ

- 8.1. Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэг байгуулах үйл ажиллагаанд “Тамхины хяналтын тухай хууль”-ийг мөрдлөг болгоно.
- 8.2. Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг явган хүний зам дээр байгуулахыг хориглох бөгөөд тухайн байгууламжийн төрлөөс хамааруулан шатах тослох материалыг хадгалж, гуравдах тослох материал болон аюултай хог хаягдал хадгалж байгаа цэг, явган хүний замаас хамгийн багадаа 5-10 метрийн зайд байрлуулна.
- 8.3. Зөвшөөрөгдсөн цэгээс бусад цэгт утаат тамхи татахийг хориглох тэмдэг тэмдэглэгээг байршуулах бөгөөд хаях хогийн сав нь зориулалт бүхий тасалгаатай, цэвэрлэх, халдваргүйжүүлэх боломжтой байна.



Зураг 10. Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэг (Жишээ зураг)

9. ГАДНА ХАЯГ, БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН БИЧВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 9.1. Авто засвар үйлчилгээний байгууллагын нэр байршлын мэдээллийн самбарыг “MNS 5283:2022 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага” үндэсний стандарт, “UCS 1403B:2022 Гадна мэдээллийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартын шаардлагад нийцүүлэн байрлуулна.
- 9.2. Самбарын бичвэр нь харагдахуйц, гаргацтай, өөрөөсөө буюу гаднаас гэрэлтүүлэгтэй, аудио болон дүрст видео төхөөрөмжөөр тоноглогдсон байж болно.
- 9.3. Авто засварын газрын нэр, ажиллах цагийн хуваарь, бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг агуулсан байна.



Зураг 11. Авто засварын газрын мэдээллийн самбар (Жишээ зураг)


- 9.4. Худалдаа үйлчилгээний байгууллага нь гадна хана, дээврийн хэсэгт өөрийн нэрийг том хэмжээгээр бичих буюу биет хэлбэрээр байрлуулж болох бөгөөд нэрийн бичвэрт холбогдох стандартыг мөрдлөг болгоно.
- 9.5. Гадна байрлах мэдээллийн байгууламжийн бичвэрийг Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 5 дахь заалтын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд Монгол бичиг (уйгуржин)-ээр бичиж болно.
- 9.6. Шаардлагатай тохиолдолд байгууллагын нэрийн бичвэрийг англи хэлээр бичиж болох бөгөөд англи хэл дээрх бичвэр нь монгол бичвэрийн доод талд байрлаж, түүнээс 2 дахин бага өндөртэй байх, эсхүл Монгол /кирилл/ бичвэрийн зүүн гар талд байрлаж, түүнтэй ижил өндөртэй байна.
- 9.7. Байгууллагын нэрийн бичвэр нь утга төгөлдөр, ойлгогдохуйц, өнгө дизайн сайтай, хотын үзэмжид нийцсэн, орчин үеийн технологийн шийдлийг ашигласан байх бөгөөд ашиглагч байгууллагын зүгээс арчилгаа засвар, үйлчилгээг хийж, өнгө үзэмж бүрэн бүтэн байдлыг тогтмол хангуулна.



Зураг 12. Авто засварын газрын нэрийн бичвэр (Жишээ зураг)

10. АЮУЛТАЙ БОЛОН ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ТҮР ХАДГАЛАХ ЦЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 10.1. Аюултай хог хаягдлыг зориулалтын бат бөх саванд харилцан урвалд ордоггүй саванд түр хадгалж аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий газартай гэрээ байгуулан хүлээлгэн өгч ажиллана.
- 10.2. Аюултай хог хаягдал хадгалах агуулах нь Хог хаягдлын тухай хуулийн 25.3, MNS 6458:2014, UCS 1703A:2022 Аюултай хог хаягдлын менежмент хотын стандарт, БНБД 31-19-10, 2010 Агуулахын барилгын норм ба дүрэм болон дээрх стандартуудад тусгагдсан шаардлагыг хангасан байна.



Зураг 13. Авто засварын газрын аюултай хог хаягдлын агуулах (Жишээ зураг)

- 10.3. Бусад хог хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлыг төрөлжүүлэн түр хадгалж аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан хүлээлгэн өгнө.
- 10.4. Энгийн хог хаягдлыг түр хадгалах эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хог ачих зориулалт бүхий орц гарцтай байхаар төлөвлөнө.
- 10.5. Хог хаягдал түр хадгалах савнууд нь UCS 1701A:2022 Хог хаягдлын менежмент нийцсэн байх шаардлагатай.




Зураг 14. Энгийн хог хаягдлыг түр хадгалах цэг (Жишээ зураг)

- 10.6. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд эрх бүхий батлагдсан шаардагын дагуу (Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаал)-ын дагуу ангилж, MNS 5344:2011 стандартын дагуу тээвэрлүүлнэ.



Зураг 15. Ангилан ялгах тэмдэг бүхий хогийн сав (Жишээ зураг)



Зураг 16. Задгай агуулахад хадгалах аюултай хог хаягдал (Жишээ зураг)

11. ШАЛГАХ ХУУДАС

Авто засварын газрын гадна орчинд тавигдах ерөнхий шаардлагыг хангаж байгаа эсэхийг Хүснэгт 1-ийн дагуу хянан шалгаж, хүлээн авна.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Авто засварын үйлчилгээ явуулж буй барилга байгууламж нь холбогдох стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Аюултай болон энгийн хог хаягдлыг түр хадгалах цэгт тавигдах шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Утаат тамхи татах цэгийг байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Авто засварын газрын гадна зогсоол талбай, түүний хучилт стандартын дагуу төлөвлөгдсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Гадна зам талбайд байршуулсан гэрэлтүүлэг нь стандартын шаардлага хангасан эсэх.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Барилгын гадна орчинд хяналтын камер байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Авто засварын үйлчилгээ эрхэлж буй барилгын гадна талбайд байршуулсан мэдээллийн самбар нь зохих шаардлага, норм, дүрмийг хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгөд нэрийн болон хаягийн бичвэрийг стандартын шаардлагын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Авто засварын газрын гадна талбайд машин, механизмаас тос, тосолгооны материал, шатахуун болон бусад хөрс бохирдуулагч бодис асгарсан тохиолдолд түүнийг тухай бүрд нь арилгах арга хэмжээ авах төлөвлөгөөтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Авто засварын газрын гадна орчин нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын үндсэн хууль
2. Хог хаягдлын тухай хууль;
3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
4. Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм;
5. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаал/;
6. Гадна зар сурталчилгаанд тавих шаардлага /Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 9/10 дугаар тогтоол/;
7. БНБД 31-03-03 Олон нийт, иргэний барилгын норм ба дүрэм;
8. БНБД 32-01-06 Хот суурины гудамж, зам төлөвлөлтийн норм ба дүрэм;
9. БНБД 30.01.04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
10. БНБД 3.01.06-09 Барилгын орчны тохижилтын ажил;
11. MNS 5025:2020 Авто үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага;
12. MNS 5342 Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага;
13. MNS 5021 Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага;
14. MNS 5011 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдлын үзлэг хийх заавар, ерөнхий шаардлага;
15. MNS 5347 Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал Ерөнхий шаардлага;
16. MNS 4596 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
17. MNS 4597 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага;
18. MNS 4759 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага;
19. MNS 5537 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж, үндсэн шаардлага;
20. UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага;
21. UCS 1201B:2022 Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага;
22. UCS 1703A:2022 Аюултай хог хаягдлын менежмент;
23. Title 33, Planning and Zoning. 33.266 Parking, Loading, And Transportation And Parking Demand Management;
24. PDH online Course C620 (6 PDH). Jerry D. Morrow, PE. Complete Parking Lot Design;
25. Siting and design guidelines for electric vehicle supply equipment. New York State Energy Research and Development Authority;
26. Pine Rivers Shire Council. On-Site car parking and service vehicle facilities.